



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/63

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийг 36.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан STEAM үйл ажиллагааны хүрээнд бага насны хүүхдүүдийн сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх зорилгоор дэвшилтэт технологид суурилсан 3 хэмжээст хөдөлгөөнт дүрслэл, дуу, дүрс бичлэг бүхий сургалтын багц хэрэглэгдэхүүнээр цэцэрлэгүүдийг хангах ажлыг зохион байгуулсугай.

2.Сургалтын багц хэрэглэгдэхүүн нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Аргун паблишинг” ХХК-тай гэрээ байгуулан, хяналт тавьж, хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

3.Сургалтын багц хэрэглэгдэхүүнийг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Аргун паблишинг” ХХК-ийн борлуулалтын менежер (Б.Өлзий-Утас)-т даалгасугай.

4.Сургуулийн өмнөх боловсролын сургалтын багц хэрэглэгдэхүүн худалдан авах гэрээний дүн болох 28,600,000 (хорин найман сая зургаан зуун мянган) төгрөг, тээврийн зардал болох 400,000 (дөрвөн зуун мянган) төгрөгийг төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

